

**ХИЛИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХАД
УДИРДАХ АЖИЛТНЫ
МАНЛАЙЛЛЫН
НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА**

Ц.Одонгэрэл

*ДХИС-ийн хилийн албаны сургуулийн
ар тал, эдийн засгийн тэнхимийн
профессор, доктор (Ph.D), хурандаа*

Товч утга: Монгол Улсын

төрийн албаны шинэтгэлийн үйл
явцад төрийн хүний нөөцийн
удирдлагын чиглэлээр баримтлах
төрийн бодлого, зорилтыг
хэрэгжүүлэх хөтөлбөр,
төлөвлөгөөнүүдийг боловсруулан
хүний нөөцийн мэдлэгийг
дээшлүүлэх, ур чадварт сургах,
хандлагыг төлөвшүүлэх хүрээнд
олон ажлыг хэрэгжүүлж ирсэн¹
байна.

Хил хамгаалах
байгууллагын удирдах ажилтны
манлайллын асуудлыг авч үзэхээс
өмнө төрийн албаны манлайллыг
төрийн бодлогын баримт
бичгүүдэд хэрхэн тодорхойлж,
хэрэгжүүлж ирсэн байдлыг
судлах нь зүйтэй хэмээн үзлээ.

¹ Одонгэрэл, Ц. Хил хамгаалах
байгууллагын удирдах ажилтны
манлайлал, хууль сахиулах удирдлагын
чиглэлээр
докторын зэрэг горилсон бүтээл. 142
дэх тал, Уб., 2024.

Монгол Улсын хувьд 1999
оноос эхлэн төрийн албан
хаагчдын мэдлэг, ур чадвар,
хандлага, түүн дотроо
манлайллын асуудалд бодлогын
түвшинд анхаарал хандуулж
ирсэн².

№	Төрийн бодлогын баримт бичиг	Алсын хараа
1	Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоол	«Үйл ажиллагааны чадах сайтай төрийн албан хаагчдыг бүрдүүлсэн байх, мэдлэг чадвартай төрийн албан хаагчидтай болсон байх, байгууллага бүр сурацлагч байгууллага болсон байх, манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангасан байх».
2	УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан «Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дүм хууль»-ын стратегийн баримт бичиг»	«Иргэдийн хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохиож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачлагатай манлайлагч, менежер бүхий цомхон чадварлаг зисийн дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албан төлөөлүүлэх».

**Хүснэгт 1. Төрийн албаны
шинэтгэлийн бодлогын баримт
бичигт манлайллын**

талаар тусгаж ирсэн байдал

“Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил
хамгаалах байгууллагын удирдах
ажилтны манлайлал,

хууль сахиулах удирдлагын чиглэлээр
докторын зэрэг горилсон бүтээл. Уб.,
2024”

Дээр дурдсанаас үзэхэд
төрийн албаны шинэтгэлийн
гурав дахь үе шатанд төрийн
албаны манлайллын асуудлыг
тусгайлан авч үзсэн бөгөөд энэ нь
Монгол Улсад төрийн албаны
шинэчлэлийг үр дүнтэй
хэрэгжүүлэх арга хэрэгсэл болсон
гэж үзсэн. Ялангуяа төрийн
захиргааны албан хаагчдын,
төрийн удирдах албан тушаалтны

² Эрдэнэбат, П. МУ-ын Прокурорын
байгууллагын удирдах албан тушаалтны
манлайллын хэв маяг,
чадварт хийсэн шинжилгээ,
удирдахуйн ухааны докторын зэрэг
горилсон бүтээл, Уб., 2015. 2 дахь тал.

гүйцэтгэлийн үнэлгээнд манлайллын үнэлгээг шалгуур болгосон байна¹.

Гэсэн хэдий ч манлайллыг дээшлүүлэх талаарх бодлого, стратегийн баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй, удирдах ажилтны манлайллын чадавх шаардлагын түвшинд хүрэхгүй байгааг нотолсон судалгааны үр дүн гарсан байна².

Удиртгал: Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайллын асуудлыг төрийн бодлого, эрх зүйн акт, байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрт хэрхэн тусгаж ирсэн байдалд мөн дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Төрөөс

хилийн талаар баримтлах бодлого

«Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого»-ын 1.5 дахь хэсэгт «...аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц

байдлаар зохион байгуулна...», 2.11 дэх хэсэгт «...улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх...», 3.3 дахь хэсэгт «...хил хамгаалах албыг зохион байгуулж, удирдах байгууллага нь мэргэжлийн байх...» гэсэн нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцээр санал болгон дэвшүүлж буй «Мэдлэг»-ийн агуулгыг илэрхийлсэн байна. Мөн тус баримт бичгийн 1.4 дэх хэсэгт «...Хилийн талаар баримтлах бодлого нь бусад улсын тусгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд тулгуурлана...», 2.6 дахь хэсэгт «..6) улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будилааныг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх...», «...иргэдийн эх оронч

¹ Мөн тэнд.

² Өлзийбаяр, В. «Төрийн албаны манлайллын өөрчлөлт». Удирдахуйн ухаанаар докторын зэрэг горилсон

бүтээл.

үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүшлийг төлөвшүүлэх...» гэсэн нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцийг санал болгон дэвшүүлж буй «Хандлага»-ын агуулгыг илэрхийлсэн байна гэж үзэх боломжтой байна.

Төрөөс хилийн талаар баримтлах баримт бичигт улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох талаар 2.1-д «Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох», 2.2-т «Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангана» гэж төрийн бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тусгасан нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон байна.

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох

бодлогын хүрээнд ХХЕГ-ын стратегийн зорилтуудын нэг болох «Хил хамгаалалтын арга, тактикийг хилийн нөхцөл байдал, бүсчилсэн хил хамгаалалтын онцлогт тохируулан өөрчилж, хилийн аюулгүй байдлыг хангах»-ын тулд төрийн зүгээс ХХБ-ыг бэхжүүлэх чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Үүний тулд эхлээд онолын үндэслэлийг¹ товч тайлбарлая.

Менежментийн шинжлэх ухаанд удирдахуйн үйл ажиллагааны далайц, хамарч буй цар хүрээ, өрнөж буй орон зай, цаг хугацааны хамаарал зэргийг харгалзан:

- Стратегийн түвшний удирдлага (дээд түвшний);
- Оперативын түвшний удирдлага (дунд түвшний);
- Тактикийн түвшний удирдлага (доод буюу анхан шатны) гэж ангилна.

Стратегийн түвшний менежмент гэж байгууллагыг урт хугацаанд амжилттай хөгжүүлэхийн тулд дээд түвшний удирдлагын алсын чиг баримжаатай хэрэгжүүлж буй менежментийг ойлгоно.

¹ Цэцэгмаа, О. Удирдахуйн ухааны лекцүүд. УБ., 2013. 15 дахь тал.

Стратегийн удирдлагыг байгууллагын хэмжээнд, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж болно.

Оперативын түвшний менежмент гэж байгууллагын томоохон хүч хэрэгслийг нэгдмэл удирдлагаар ханган завсрын зорилтуудыг биелүүлэх чиглэлээр дунд түвшний удирдлагын хэрэгжүүлж буй менежментийг ойлгоно.

Тактикийн түвшний менежмент гэж байгууллагын технологийн үйл ажиллагааг тогтсон арга зүй, стандартаар нэгжийн удирдагчийн санаачилгад тулгуурлан хэрэгжүүлж буй менежментийг ойлгоно.

Удирдахуйн үйл ажиллагааны хамрах хүрээ, орон зай, цаг хугацааны хамаарал, түүнчлэн шийдвэрлэж буй завсрын зорилтоос шалтгаалан стратеги-оперативын болон оператив-тактикийн түвшний удирдлагын үйл ажиллагаа гэж бас ангилж авч үздэг¹.

Дээрх ангиллыг харгалзан хил хамгаалах байгууллагын удирдах ажилтнуудыг (удирдах албан тушаалтнуудыг) стратегийн болон тактикийн түвшний гэж зааглаж болохоор байдаг. Харин оперативын удирдлагын түвшин тодорхой харагдахгүй байна гэж

үзэх үндэстэй. Улсын орны хэмжээнд хил хамгаалах байгууллагыг нэгтгэн удирдаж буйн хувьд ХХЕГ-ын дарга, дэд дарга, албадын дарга нар стратегийн буюу дээд түвшний менежер мөн байдаг бол, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хилийн отрядыг захирч буй дарга, орлогч нар бол тактикийн түвшний буюу анхан шатны менежер юм.

Стратегийн түвшний болон тактикийн түвшний удирдлагын холбоос болсон оперативын түвшний удирдлагын бүтцийг чухамдаа «Бүсчилсэн хил хамгаалалтын тогтолцоо» бүрдүүлэх юм. Өндөр уулын, ой тайгын, тал хээрийн, говь цөлийн болон төвийн бүсийн хил хамгаалах байгууллагуудыг жинхэнэ утгаар нь үүсгэн бэхжүүлэх нь хилийн халдашгүй дархан байдлыг хангах чухал механизм болно хэмээн үзэж байна.

Хилийн тухай хууль

Монгол Улсын Хилийн тухай хуулийн «Монгол Улсын хилийн төлөөлөгч» гэсэн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт «...Хилийн асуудлаар байгуулсан

¹ Цэцэгмаа, О. Дурдсан бүтээл. 15 дахь тал.

Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиг үүрэг ...» -тэй байхаар болон 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт «...Хилийн төлөөлөгч нь хил залгаа улсын хилийн төлөөлөгчтэй Монгол Улсын олон улсын гэрээнд заасан арга хэлбэрээр хамтран ажиллана. Хилийн төлөөлөгч хэлэлцээ хийж, шийдвэрлэх шаардлагагүй гэж үзсэн асуудлыг хилийн төлөөлөгчийн орлогч, туслагчийн уулзалтаар шийдвэрлэнэ...», мөн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт «...Хилийн төлөөлөгчийн шийдвэрлэх боломжгүй асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ...» гэж тус тус заасан нь Монгол Улсын хилийн төлөөлөгч нь ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцэд санал болгон дэвшүүлж буй «Шийдвэр гаргалт»-ын агуулгыг шууд хуульчлан илэрхийлсэн гэж үзэх боломжтой байна.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн «Улсын хил хамгаалах байгууллагын даргын бүрэн эрх» гэсэн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг «Улсын хил хамгаалах байгууллагын дарга нь хилийн цэргийн

командлагч байна», мөн зүйлийн 37.3.2 дахь хэсэгт «...улсын хил хамгаалах удирдамж, хил хамгаалалтын үйл ажиллагааны талаар тушаал гарган, хэрэгжилтэд нь хяналт тавьж, хилийн цэргийн анги, салбарыг нэгтгэн удирдах...» гэж ХХБ-ын шийдвэр гаргах бүрэн эрх бүхий удирдах албан тушаалтныг тодорхойлон хуульчилсан.

Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагад ангийн захирагч, захирагчийн орлогчид цэргийн дээд боловсролтой, цэргийн ухааны магистр түүнээс дээш зэрэгтэй байх тусгай шаардлагыг тавьж байгаа нь хил хамгаалах алба, үйл ажиллагаа цэргийн удирдлагаар зохион байгуулдаг. Цэргийн бакалаврын мэргэжлийг Монгол Улсад ДХИС-ийн Хилийн албаны сургууль, ҮБХИС-ийн Цэргийн дээд сургууль, гадаадад орос, хятад, гуравдагч орны цэргийн мэргэжлийн сургууль олгож, хүний нөөцийг бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд цэргийн мэргэжил эзэмших хүсэл сонирхолтой залуусын тоо огцом буурч байгаа нь хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого алдагдах, өрсөлдөөн

багассанаас чанаргүй удирдах албан тушаалтнууд томилогдох зэрэг эрсдэл тулгарч байна. Иймээс цэргийн мэргэжлийн бакалавр, магистр, докторын мэргэжил эзэмшүүлдэг үндсэн сургууль болох Хилийн албаны сургуульд сурах сонсогчдын тоог нэмэгдүүлэх, багшийг чадавхжуулах, сургалт, дадлага зохион байгуулах нөөц хөрөнгө, материаллаг байдлыг сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Док. Ч.Сайнтөрийн «Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам» сэдэвт бүтээлд хил хамгаалах байгууллагын хүний нөөцийг сонгох, бүрдүүлэх, сургах, бэлтгэх чиглэлээр олон талт арга хэмжээг хэрэгжүүлсээр байгаа хэдий ч практик үйл ажиллагаанд хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, сургах, бусад шат дараалсан үйл ажиллагаанд шийдлээ хүлээж буй асуудлууд байгааг тодорхойлон¹ хүний нөөцийг бүрдүүлэхэд удирдах ажилтны сургалт, бэлтгэл, албан тушаалын өсөлт, нэг суралцагчийн академид 2 жил

суралцах зардлын тооцоог судалсан байна. Үүнд: Хил хамгаалах байгууллага удирдах бүрэлдэхүүний академийн сургалтыг дотооддоо ДХИС-ийн Удирдлагын академи, ҮБХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академи, гадаадад ОХУ-ын «Жанжин штабын академи», «Фрунзын нэрэмжит цэргийн академи», «Хилийн албаны аюулгүй байдлын академи» болон БНХАУ, БНСУ, БНЭУ²-ын цэргийн академиудад сургаж бэлтгэн, нэг суралцагчийн зардалд улсын төсвөөс 31.1 сая төгрөгийн, 2012-2018 онд хил хамгаалах байгууллагын захиалгаар суралцсан нийт суралцагчдын зардалд 2 тэрбум³ гаруй төгрөгийн зардал гарсан байна.

ДХИС-ийн Хилийн албаны сургуульд хэрэгжүүлдэг «Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийн БМИҮЗ-д хүргүүлсэн тайланд магистрын хөтөлбөрийн харьцуулалтыг дотоод, гадаадын сургалтын хөтөлбөртэй харьцуулсан


¹ Сайнтөр, Ч. Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам. Хил судалын докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2020. 55 дахь тал.

² Мөн тэнд. 77 дахь тал.

³ Сайнтөр, Ч. Дурдсан бүтээл. 81 дэх тал.

шинжилгээг дараах зургаар
харуулж байна. Үүнд:

**Гадаадын ижил төстэй
хөтөлбөртэй харьцуулсан
судалгаа**



Зураг 1. “Хил судлал” магистрын хөтөлбөрийн ОХУ-ын академийн сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийг ОХУ-ын Батлан хамгаалах яамны «Жанжин штабын академи»-ийн 2 жил, ОХУ-ын Фрунзын академийн «Цэргийн анги, нэгтгэлийн удирдлагын магистр»-ын 2 жилийн сургалтын хөтөлбөрүүдийн судлах багц цаг цаашлаад ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн харьцааг судалж үзэхэд «Хил судлал» магистрын

сургалтын хөтөлбөр нь цэргийн зохион байгуулалт, хил хамгаалалтын ижил хэлбэрийн сургалт, арга зүй, тактикийн дэлхийн жишиг бүхий бусад улс, орны хөтөлбөртэй эн зэрэгцэхүйц хэмжээнд хийгдсэн гэж үзэж болохоор байна.

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийн багц цагийн агуулгыг ижил түвшний сургалтын үйл ажиллагаа

явуулдаг сургалтын хөтөлбөрийн агуулгатай харьцуулсан байдлыг дараах зурагт үзүүлэв. Үүнд:



Зураг 2 . “Хил судлал” магистрын хөтөлбөрийг МУ, ОХУ-ын академийн сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийг ОХУ-ын БХЯ-ны «Жанжин штабын академи»-ийн 2 жил, ОХУ-ын Фрунзын академийн «Цэргийн анги, нэгтгэлийн удирдлагын магистр»-ын 2 жилийн сургалтын

хөтөлбөр, ҮБХИС-ийн БХУА-ийн «Стратеги тактик, команд штаб», Удирдлагын академийн «Хил хамгаалалтын стратеги тактик-удирдлага» сургалтын хөтөлбөрийн үндсэн хөтөлбөрүүдтэй харьцуулахад

«Хил судлал» сургалтын хөтөлбөрийн нийт эзэлбэл зохих багцын хэмжээ бусад хөтөлбөрийн жишигт нийцэж байна

Дотоодын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан байдал

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөрийг ДХИС-ийн Удирдлагын академи, Ахисан шатны сургууль, ҮБХИС-ийн БХУА-д хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөртэй харьцуулан дараах зургаар харууллаа. Үүнд:




Зураг 3. “Хил судлал” магистрын хөтөлбөрийг бусад сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа
Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

«Хил судлал» магистрын сургалтын хөтөлбөр нь ҮБХИС-ийн «Стратеги тактик, команд штаб», «Гамшиг судлал» магистрын хөтөлбөртэй 34 багц

цагийн багтаамжаар «ижил», Удирдлагын академийн «Стратеги-тактикийн удирдлага» магистрын сургалтын хөтөлбөрөөс 4 багц цагийн дутуу

төлөвлөгдсөн боловч Команд сургалтыг илүү явуулдаг нь штабын сургалтыг 2 багц цагаар харагдаж байна. илүү байгаа нь танхимын бус



Зураг 4. “Хил судлал” магистрын хөтөлбөрийн багц цагийн харьцуулсан судалгаа
Эх сурвалж: Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, диссертаци. Уб., 2024

ДҮГНЭЛТ

«Хил судлал» магистрын хөтөлбөрийг цэргийн ахисан түвшний мэргэжил олгодог хөтөлбөрийн багц цагийн агуулгаар харьцуулан үзэхэд мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүд нь бага буй боловч суралцагчдад удирдах ур чадвар олгох, эрдэм шинжилгээ судалгааны ажилд сургах тал дээр илүү анхаарч байгаа нь сайшаалтай байна.

ХХБ-ын тодорхой нэгжийн удирдах албан тушаалтны ажлын үр дүнг тус байгууллагын дотоод харилцааг зохицуулж буй хуульчилсан актуудын хэм хэмжээгээр үнэлэн тодорхойлж байгаа нь ололттой тал хэдий ч удирдах ажилтанд өгч буй хамт олны үнэлгээг орхигдуулсан нь «Манлайлал»-ын асуудалд зайлшгүй авч үзэх шаардлагатай байна.

ХХБ-ын хэмжээнд удирдах ажилтны манлайллын чиглэлээр

тусгайлан гаргасан дүрэм, заавар, тушаал зэрэг бие даасан эрх зүйн хэм хэмжээ бүхий хуульчилсан акт байхгүй ч ХХБ-ын удирдах ажилтны «Манлайлал»-ын бүтцээр санал болгон дэвшүүлж буй загвар буюу албан тушаалтны мэдлэг чадвар, туршлага, хандлагад болон үнэлгээнд тавигдах зарим хэм хэмжээг тодорхойлсон, иш татсан заалтууд бүхий дараах дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байгаа юм. Үүнд:

1. Хил хамгаалах байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм;
2. Хил хамгаалах байгууллагын ажил дүгнэх журам тус тус болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Хилийн тухай хууль, 2016 он
УИХ, Засгийн Газрын Тогтоол, бодлогын баримт бичиг:
3. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он МУЗГ-ийн “Алсын хараа-2050” хөтөлбөр, 2020 он
4. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухай хууль, 2010 он
5. Хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн орчин” сэдэвт судалгааны төсөлт ажил. Уб., 2018.

Диссертаци:

6. Одонгэрэл, Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал. Хууль сахиулах удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2025.
7. Сайнтөр, Ч. Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам, хил судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020. 27 дахь тал.
8. Эрдэнэбат, П. Монгол Улсын Прокурорын байгууллагын удирдах албан тушаалтны манлайллын хэв маяг, чадварт хийсэн шинжилгээ. Удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2015.